



**АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ  
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 12 сарын 07 өдөр

Дугаар A/330

Улаанбаатар хот

Г Зөвшөөрлийн бичгийн үнийг түр  
хугацаатай шинэчлэн өөрчлөх  
Тухай

П

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Зам, тэзвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 301 дүгээр тушаалаар батлагдсан "Тээвэрлэлттэй холбогдсон баримт- бичгийг Хэвлүүлэх, ашиглах журам"-ын 2.2.1 дэх заалт, Зам, тээврийн сайдын 2013 оны 261 дүгээр тушаалын 1 дэх заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 76 дугаар тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 55 дугаар тогтоолоор батлагдсан "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 4.1.4, 6.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улс хоорондын байнгын ачаа тээвэрт олгох зөвшөөрлийн бичгийн ашиглалтын хугацаа дуусч байгаатай холбогдуулан 90 хоногийн хугацаатай олгогддог "С" төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийн үнийг 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд 30000 /гучин мянга/ төгрөгөөр олгосугай;
2. Зөвшөөрлийн бичгийн үлдэгдлийг 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн тооллогын бүртгэлээр гаргаж, уг үнэ дээр нэмэгдсэн өргтийн албан татварыг нэмж тооцон, орлогыг холбогдох дансанд төвлөрүүлж ажиллахыг Санхүү эдийн засгийн хэлтэс /Я.Оюунсүрэн/-т болон хилийн боомттой аймгийн автотээврийн төв, салбарын дарга нарт тус тус даалгасугай.
3. Улс хоорондын тээвэрлэлтийн "С" төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийг тогтоосон үнээр аж ахуйн нэгж, байгууллагад олгож, борлуулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Тээвэр зохицуулалтын хэлтэс /Д.Батбаяр/-т болон хилийн боомттой аймгийн автотээврийн төв, салбаруудад тус тус үүрэг болгосугай;
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд захирал /Ш.Батсайхан/-д даалгасугай.

ЗАХИРАЛ

П.ДЭЛГЭРНАРАН

